

**ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫН МЭДҮҮЛЭГ БОЛОН  
ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ ГАРГАХ  
ЗАРИМ АЛБАН ТУШААЛТНЫ ЖАГСААЛТ**  
/Шинэчилсэн найруулга/

Нэг.Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд зааснаас гадна дараах албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргана:

1.1.Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, Монгол Улсын Засгийн газраас хөрөнгө оруулагчтай байгуулсан тогтвортой байдлын гэрээгээр үйл ажиллагаа нь зохицуулагдаж байгаа төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан /тухайн хуулийн этгээдийн удирдах албан тушаалд ажиллаж байгаа гадаадын иргэн нэгэн адил хамаарна/;

1.2.Засгийн газрын тодорхой чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор улсын төсвөөс санхүүжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, түүнчлэн уг арга хэмжээнд зориулан олгосон хандив, буцалтгүй тусламжийг захиран зарцуулж байгаа Засгийн газрын тусгай сангийн удирдах албан тушаалтан /олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу зээл, тусламж, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн зохицуулагч, удирдах албан тушаалтан нэгэн адил хамаарна/;

1.3.улсын төсвөөс санхүүжилт авдаг болон аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар байгууллага, хороо, төвийн удирдах албан тушаалтан.

1.4.Монголбанкны газар, хэлтэс /салбар, алба/-ийн захирал, ахлах мэргэжилтэн, улсын байцаагч-хянан шалгагч, нягтлан бодогч, өр барагдуулах ажилтан, банкны эрх хүлээн авагч.

Хоёр.Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлд заасан улс төрийн, төрийн захиргааны болон төрийн тусгай, төрийн үйлчилгээний албаны дараах ангилал, зэрэглэлийн албан тушаалтнаас бусад албан тушаалтан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргана:

2.1.улс төрийн албан тушаалтны бүрэн эрхийн хугацаанд зөвхөн өөрт нь үйлчлэх туслах, бие төлөөлөгч, хэвлэлийн ажилтан;

2.2.Монгол Улсын Их Хурал дахь болон бүх шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх нам, эвслийн бүлгийн ажлын албаны ажилтан;

2.3.төрийн захиргааны албаны “ТЗ-1”-“ТЗ-5”-д хамаарах албан тушаалтан;

2.4.боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэнд, соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албаны “ТҮШУ-4”, “ТҮМБ-4”, “ТҮМБ-5”, “ТҮМБ-6”, “ТҮЭМ-5”, “ТҮСУ-7”, “ТҮСУ-8”-д хамаарах албан тушаалтан;

2.5.боловсрол, эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтай дүйцүүлэн жиших “ТҮМБ-7”, “ТҮМБ-8”, “ТҮЭМ-6”, “ТҮЭМ-7”-д хамаарах мэргэжлийн албан тушаалтан;

2.6.шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын “ТТ-1”-“ТТ-10”-д хамаарах албан тушаалтан болон “ТТ-11”-ийн шүүхийн шийдвэр гүйцэтгэгчээс бусад албан тушаалтан;

2.7.батлан хамгаалах, зэвсэгт хүчний байгууллагын “ТТ-1”-“ТТ-8”-д хамаарах албан тушаалтан;

2.8.онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын “ТТ-1”-“ТТ-11”-д хамаарах албан тушаалтан;

2.9.цагдаагийн байгууллагын “ТТ-1”-“ТТ-8”-д хамаарах албан тушаалтан;

2.10.хил хамгаалах байгууллагын “ТТ-1”-“ТТ-10”-д хамаарах албан тушаалтан;

2.11.тагнуулын байгууллагын “ТТ-1”-“ТТ-9”-д хамаарах албан тушаалтан;

2.12.Тахарын албаны “ТТ-1”-“ТТ-11”-д хамаарах албан тушаалтан;

2.13.хууль сахиулагчийг бэлтгэх сургуулийн “ТТ-1”-“ТТ-13”-д хамаарах албан тушаалтан;

2.14.шүүхийн шинжилгээний байгууллагын “ТТ-1”-“ТТ-8”-д хамаарах албан тушаалтан болон “ТТ-9”, “ТТ-10”-ын шинжээчээс бусад албан тушаалтан;

2.15.төрийн захиргааны албаны “АА-9”-“АА-11”-д хамаарах албан тушаалтан;

2.16.Авлигатай тэмцэх газрын туслах ажилтан;

---оОо---

Тайлбар: “ТЗ” ангилалд төрийн захиргааны албан тушаалтан, “ТТ” ангилалд төрийн тусгай албаны албан тушаалтан, “ТҮШУ” ангилалд шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалтан, “ТҮМБ” ангилалд мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалтан, “ТҮСУ” ангилалд соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалтан, “ТҮЭМ” ангилалд эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалтан, “АА” ангилалд Монгол Улсын Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллага болон тэдгээртэй адилтгах байгууллагын ажлын албаны албан тушаалтан.